

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖТАЙ ҮҮРГИЙН ШҮРШИГЧ БАГАЖ АШИГЛАН 76000 ГА ТАЛБАЙД ТЭМЦЭХ АЖИЛ

ТЭМЦЛИЙН АЖИЛ ХИЙХ ГАЗРУУД, ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН АГУУЛГА ҮЕ ШАТУУД БЭЛТГЭЛ

Багц № 1: Булган, Орхон, Сэлэнгэ аймгийн ойн сан бүхий сумдын ойн санд 32.000 га талбайд;

Багц № 3: Хөвсгөл, Хэнтий, Төв аймгуудын ойн сан бүхий сумдын ойн санд 44.000 га талбайд ажлыг зохион байгуулна.

- Хэт бага эзлэхүүнээр шүршигч багажтай байх, (хошууны тохиргоо: Calibrated Jet (0.80 mm). 0.28 Ltr/min | 61.0 µm- Calibrated Jet (2.00 mm). 1.79 Ltr/min | 91.3 µm)
- Багаж тоног төхөөрөмжүүдийн техникийн паспорт, техникийн үзүүлэлтүүдийг нотлох баримт бичгийг хавсарган ирүүлэх шаардлагатай.
- Хэт бага эзлэхүүнээр шүршигч 50 ширхэг багажтай байна. /холбогдох техникийн паспорт, техникийн үзүүлэлтийг хавсарган ирүүлнэ./
- Ойн хөнөөлт шавжтай үүргийн шүршигч багаж ашиглан тэмцэх ажлыг гүйцэтгэхдээ орон нутаг болон ЦУОШГ-аас тухайн бүс нутгийн цаг уурын мэдээг урьдчилан авсан байх,
- Үүргэн шүрших төхөөрөмж, бусад шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн техник үйлчилгээг бүрэн хийн, тэмцлийн ажилд гаргахад бэлэн болгосон байх,
- Тэмцлийн ажилд хэрэглэгдэх техник тоног төхөөрөмжүүд дээр ажиллах улирлын болон түр ажилчдыг ажилчдыг дадлагажуулах;
- Үүргийн шүршигч багаж тус бүрд тэмцлийн ажлын хөдөлгөөнийг бүртгэх байршил тодорхойлох Earthranger платформыг гар утсанд суулган аж ахуйн нэгжийн нэр дээрх админ эрхээр замын зураглал бичих хэсгийг идэвхжүүлэн өдөр бүрийн нислэгийг замын зураглалыг Earthranger платформд илгээхэд бэлтгэх. /Админ эрхийг Ойн газраас нээлгэж авна./
- Earthranger платформын эрхээр ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажил, тэмцлийн ажлын үр дүнг өдөр бүр зааврын дагуу илгээх зааварчилгааг бэлтгэсэн байх;
- Үүргийн шүршигч багаж тус бүрд тэмцэх ажлын хөдөлгөөнийг бүртгэх байршил тодорхойлох багаж /GPS/-аас өдөр бүрийн явсан маршрутын мэдээг хуулж авч хадгалах;
- Тэмцлийн ажилд хэрэглэгдэх бэлдмэл бодисыг зориулалтын битүүмжлэгдсэн тээврийн хэрэгслээр тээвэрлэн, тэмцлийн ажил явуулах газар нутагт хүргэх ажлыг зохион байгуулах;

- Тэмцлийн ажилд хэрэглэгдэх техник тоног төхөөрөмжүүдийн шүрших хошууг тохируулах;
- Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажлыг явуулах технологийн карт боловсруулах;
- Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд ашиглах 1:100000-ын байр зүйн болон 1:50000-ны масштабтай ойн тархалтын зураг дээр тэмцлийн ажил явуулах талбайг тэмдэглэх;
- Тэмцлийн ажлын өдөр тутмын гүйцэтгэлийг бүртгэх загвар бэлтгэсэн байх;
- Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд ажиллах ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа бэлтгэн өгч, тухай бүрд нь зааварчилгааны хуудсыг бэлтгэх;
- Тэмцлийн ажилд ажиллах улирлын болон түр ажилчдыг дадлагажуулан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга өгөх;
- Тэмцлийн ажил явуулах бүс нутгийн ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын тухай мэдээ, зураглалтай танилцах, тэмцлийн ажил явуулах газар нутгийг судлан холбогдох бэлтгэлийг хангах;

**ҮҮРГИЙН
ШҮРШИГЧ БАГАЖ
АШИГЛАН
ТЭМЦЭХ**

Доор дурдсан аймгуудын ойн сан бүхий сумдад тэмцэх ажлыг зохион байгуулна. Үүнд:

д/д	Тэмцлийн ажил явуулах сумын нэр	Тэмцэл явуулах талбай, га
1	Булган, Орхон, Сэлэнгэ аймгийн ойн сан бүхий сумдын ойн санд	32000
3	Хөвсгөл, Хэнтий, Төв аймгуудын ойн сан бүхий сумдын ойн санд	44000
НИЙТ ДҮН		76000

д/д	Техникийн шаардлага	Нийлүүлэгчийн санал
1.	400 нанометрээс багагүй хэмжээтэй дусал бүхий мананцар үүсгэн ажлын шингэнийг шүрших боломжтой шүршигч багажуудтай байх	
2.	Үүргийн шүршигч багажууд нэг удаагийн цэнэглэлтээр 0.5 га-аас багагүй талбайг хамран шүршилт хийх боломжтой байх	
3.	Шүршигч тоног төхөөрөмжийн моторын хүчин чадал 5 м.х-ээс багагүй байх ба шүрших өндөр нь 8 метр болон түүнээс их байх	
4.	Бүрэн ажиллагаатай бэлдмэл бодис сорох гаргах мотопомптой байх.	
5.	Тохируулах хошуу бүхий иж бүрэн шүршигч тоног	

	төхөөрөмжтэй байх	
6.	Ажил гүйцэтгэх хугацаанд багажийн техникийн үзүүлэлтээс хамааран 20 хоногийн хугацаанд багтаан тэмцлийн ажил явуулах боломжтой хэмжээний үүргийн шүршигч багажуудтай байх	
7.	Ажлыг гүйцэтгэх хугацаа: 2024 оны 06 дугаар сарын 15-ээс 2024 оны 07 дугаар сарын 10-ны дотор байна.	

Ойн хөнөөлт шавжтай үүргийн шүршигч багаж ашиглан тэмцэх ажлыг гүйцэтгэхдээ орон нутаг болон ЦУОШГ-аас тухайн бүс нутгийн цаг уурын мэдээг урьдчилан авсан байна.

Багаж тоног төхөөрөмжүүдийн техникийн паспорт, техникийн үзүүлэлтүүдийг нотлох баримт бичгийг хавсарган ирүүлэх шаардлагатай.

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцлийн ажил явуулахаас өмнө тархалт голомтыг тогтоох судалгаа хийн дээж талбайн тооллогын хүснэгтийн дагуу тэмдэглэл үйлдсэн байна.

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажил гүйцэтгэсэн хойш “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын үр дүнг тооцох ажилд тавигдах ерөнхий шаардлага MNS 6534:2015” стандартын дагуу дээж талбайн тооллогын хүснэгтийн дагуу тэмдэглэл үйлдсэн байна.

Тэмцлийн ажлын өдөр тутмын гүйцэтгэлийг хэсэглэл, ялгарал, газрын нэрээр гаргах, нэг үүргийн шүршигч багаж нэг өдөрт хэдэн литр бэлдмэл зарцуулсан, үүргийн шүршигч багаж тус бүрийн хөдөлгөөнийг байршил тодорхойлогч багажаар бүртгэн явсан замыг ship өргөтгөлтэй файлаар хадгалах, ойн тархалтын зураг дээр тэмдэглэн танилцуулах зураг бэлтгэн товч тайлан гарган ажиллана.

Уг гүйцэтгэлийн өдөр тутмын товч тайлан мэдээг ажлын гүйцэтгэлд хяналт тавьж буй төслийн менежерийн анхны шаардлагаар саадгүй хувилан өгөх үүрэгтэй.

Тэмцлийн ажил явуулсан талбайг хүлээн авахдаа 1000 га хүртэлх талбайд 100 га тутамд нэг хяналтын дээж талбай, 1000 га-аас дээш талбайд 500 га тутамд нэг хяналтын дээж талбай байгуулан тэмцлийн ажил явуулахаас өмнө болон дараа нь тооллого хийн үр дүнг тооцсон байна.

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх бүс нутагт хяналтын талбай байгуулан тэмцлийн өмнөх болон дараа харьцуулсан үр дүнг гаргасан байна.

Тэмцлийн ажлын өмнөх судалгаа болон тэмцлийн ажлын үр дүнг тооцох тус тус хүснэгтийг зааврын дагуу газар дээр нь бөглөсөн байх;

Үүргийн шүршигч багаж тус бүрд тэмцлийн ажлын хөдөлгөөнийг

бүртгэх байршил тодорхойлох Earthranger платформыг гар утсанд суулган аж ахуйн нэгжийн нэр дээрх админ эрхээр замын зураглал бичих хэсгийг идэвхжүүлэн өдөр бүрийн нислэгийг замын зураглалыг Earthranger платформд илгээсэн байна; /Админ эрхийг Ойн газраас нээлгэж авна/

Earthranger платформын эрхээр ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажил, тэмцлийн ажлын үр дүнг өдөр бүр зааврын дагуу илгээх зааварчилгааг бэлтгэсэн байх;

Үүргийн шүршигч багаж тус бүрд тэмцэх ажлын хөдөлгөөнийг бүртгэх байршил тодорхойлох багаж /GPS/-аас өдөр бүрийн явсан маршрутын мэдээг хуулж авч хадгалах;

Ойн хөнөөлт шавжтай гэрлэн урхи, дэлгэц ашиглан тэмцэх ажлыг гүйцэтгэхдээ “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд тавигдах ерөнхий шаардлага MNS 6532:2015”, стандартыг мөрдөж ажиллана.

Тэмцлийн ажлын өдөр тутмын гүйцэтгэлийг хэсэглэл, ялгарал, газрын нэрээр гаргах, үүргийн шүршигч багаж явсан байршлыг хадгалах, ойн тархалтын зураг дээр тэмдэглэн танилцуулах зураг бэлтгэн товч тайлан гарган ажиллана.

Тэмцлийн ажлын үр дүнг тооцохдоо “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын үр дүнг тооцох ажилд тавигдах ерөнхий шаардлага MNS 6534:2015” стандартыг мөрдөж ажиллана. Тэмцлийн ажил явуулсан талбайг хүлээн авахдаа 1000 га хүртэлх талбайд 100 га тутамд нэг хяналтын дээж талбай, 1000 га-аас дээш талбайд 500 га тутамд нэг хяналтын дээж талбай байгуулан тэмцлийн ажил явуулахаас өмнө болон дараа нь тооллого хийн үр дүнг тооцон хүлээн авна.

Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг тухайн багцад ажиллуулах инженер, техникийн ажилтныг ажилласан байна. */Тухайн багцын удирдах болон инженер, техникийн ажилтнууд ажиллуулаагүй тохиолдолд гэрээт ажлыг гүйцэтгэх боломжгүй гэж үзэн гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна./*

Ойн хөнөөлт шавжтай агаарын хөлөг ашиглан тэмцэх ажлын явцын болон гүйцэтгэлийн мэдээ, видео, фото зураг хэлбэрээр тухайн орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл цахим социал сувгаар мөн захиалагч байгууллага Ойн газрын хэвлэл мэдээллийн хариуцсан мэргэжилтэнд өдөр тутмын мэдээг тогтмол өгсөн байна.

Ойн хөнөөлт шавжтай үүргийн шүршигч багаж ашиглан тэмцэх ажлын хүрээнд “Ойн хөнөөлт шавжтай микробиологийн аргаар тэмцэх ажилд тавих ерөнхий шаардлага” MNS6535:2015, “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын үр дүнг тооцох ажилд тавих ерөнхий шаардлага” MNS 6534:2015 стандартуудын дагуу үр дүнг тооцон, тэмцэх ажилд хэрэглэсэн микробиологийн бэлдмэлийн зарцуулалт, үр дүнг, аймаг, сум, баг, газрын нэр, хэсэглэл, ялгарлын дугаар, үүргийн шүршигч багаж тус бүр явсан байршлыг харуулан, ойн тархалтын зургийн хамт явцын болон эцсийн тайланд тусган явцын тайланг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Ойн газарт ирүүлнэ.

Тэмцсэн талбайг хүлээлгэн өгөх

Тэмцлийн ажил явуулсан талбайг орон нутгийн эрх бүхий албан тушаалтнаар батлуулан, захиалагчаас томилогдсон төслийн менежер, орон нутгаас томилогдсон ажлын хэсэгт актаар хүлээлгэн өгөх, актын эх хувийг тайланд хавсарган ирүүлнэ.

Тэмцлийн ажлын үр дүнг тооцохдоо “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын үр дүнг тооцох ажилд тавигдах ерөнхий шаардлага MNS 6534:2015” стандартыг мөрдөж ажиллана. Тэмцлийн ажил явуулсан талбайг хүлээн авахдаа 1000 га хүртэлх талбайд 100 га тутамд нэг хяналтын дээж талбай, 1000 га-аас дээш талбайд 500 га тутамд нэг хяналтын дээж талбай байгуулан тэмцлийн ажил явуулахаас өмнө болон дараа нь тооллого хийн үр дүнг тооцон хүлээн авна.

Тэмцлийн ажлын техникийн үр дүн 75%-аас багагүй байхад тэмцлийн ажил явуулсан талбайг хүлээн авна.

Зөрчил, гологдол арилгах

Тэмцлийн ажил явуулсан талбайг хүлээн авахад гарсан зөрчил дутагдлыг гүйцэтгэгч залруулах үүрэгтэй.

Тэмцлийн ажлын үр дүн заасан хувь хэмжээнд хүрээгүй тохиолдолд гүйцэтгэгч тэмцлийн ажлыг өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж дахин комисст хүлээлгэн өгнө.

Энэхүү шаардлагыг биелүүлж ажиллахаа тендерт оролцогч захиалагчид албан бичгээр тодорхойлолт гаргаж өгөх үүрэгтэй.

Тайлан боловсруулах

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн ажлын тайланг аймаг тус бүрээр хийж захиалагчид 2 хувь ирүүлнэ. Тайлан доор дурдсан бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

а/ “Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн ажлын тайлан”;

б/ 1:50000-ны масштабтай ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцлийн ажил явуулсан талбайн зураг;

в/ 1:100000-ны масштабтай ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын тойм зураг.

а. “Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн ажлын тайлан”-д:

Ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын судалгаа явуулан хөнөөлт шавжийн тархалт, голомт, хөнөөлийн голомт, дахин сэргэн ургах чадвараа алдсан талбайг ой зохион байгуулалтын материалын хэсэглэл ялгарлын талбай бүрээр гарган хүснэгтээр оруулна.

Ойн хөнөөлт шавжтай үүргийн шүршигч багаж ашиглан тэмцэх ажлыг гүйцэтгэсэн орон нутаг болон ЦУОШГ-аас тухайн бүс нутгийн сарын 10 хоногоор цаг уурын мэдээг тайланд хавсарган ирүүлнэ.

Түүнчлэн зонхилон хөнөөл учруулж буй шавжийн зүйлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн биологи, экологийн зарим онцлог шинжүүд, хөгжлийн үе шатуудын талаарх мэдээлэл, тоо толгойн нягтшил, хэт олшролын өнөөгийн байдал, өсөлтийн динамик, цаашид авах арга хэмжээний талаарх мэдээллийг багтаана.

Дээж талбайн тооллого болон бусад судалгааны ажлын үед авсан гэрэл зураг, ойн төлөв байдлын зураг, хөнөөлт шавжид

нэрвэгдсэн ойн ерөнхий байдлын зураг, тэмцлийн ажлын үр дүнд ой сэргэн ургасан байдлыг харьцуулсан зургийг тайланд хавсаргана.

Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын бэлтгэл, зохион байгуулалт, гүйцэтгэсэн хугацаа, бүрэлдэхүүн, ажил гүйцэтгэсэн технологийн мэдээлэл, тэмцлийн ажил явуулсан талбайн мэдээллийг тайланд багтаах ба тэмцлийн ажил явуулсан талбайн зураг, орон нутагт хүлээлгэн өгсөн актыг эх хувиар хавсарган ирүүлнэ.

Түүнчлэн тэмцлийн ажил эхлэхийн өмнө дээж талбай байгуулан хөнөөлт шавжийн нягтшилыг тодорхойлсон мэдээллийг дээж талбай тус бүрээр, үр дүнг тооцохоор байгуулсан дээж талбай дээрх тооллогын мэдээллийг тооллого хийсэн өдөр тус бүрээр гарган тайланд оруулна.

б. “Ойн хөнөөлт шавжтай тэмцсэн ажил явуулсан талбайн зураг”-т: Хэсэглэл, ялгарлын хил, дугаар, талбай, газрын төрлийн ангилал тэмдэглэгээ, модны төрөл, насны бүлэг, газар ус, уул, өндөрлөг тоотын нэр, газар зүйн байрлалын солбицлын торлолд, зургийн масштаб, проекц, таних тэмдэг эдгээрийг ой зохион байгуулалтын технологийн зааварт заасан стандартын дагуу гүйцэтгэж оруулна.

Тэмцлийн ажил явуулсан талбайг арга тус бүрээр ялган харуулах ба талбайн хэмжээг тусад нь хүснэгтэд хийн зурагт хавсарган ирүүлнэ.

Ойн хөнөөлт шавжтай тэмцлийн ажил явуулсан талбайн зургийг сум тус бүрээр гарган тайланд хавсаргана.

в. “Ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын тойм зураг”-т ойн хөнөөлт шавж, өвчний тархалтыг зүйлийн бүрэлдэхүүн тус бүрээр гарган харуулна. Ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын тойм зургийг сум тус бүрээр гарган тайланд хавсаргана.

Тайланг захиалагчийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэн өгнө. Хэрэв тайланд зөрчил гологдол илэрсэн бол түүнийг арилгах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ.

Зөрчил гологдлыг арилгасан тухай төслийн менежер мэдэгдэл гарган дахин даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсны дараа эцсийн шатны санхүүжилтийг олгоно.

Зураг боловсруулалтын ажлыг Засгийн газрын 2009 оны 1-р сарын 28-ны өдрийн 25-р тогтоолын дагуу олон улсын WGS-84 солбицлын систем, өндрийн сүлжээний Балтийн тэнгисийн тогтолцоог, том дунд масштабын байр зүйн зураглалд дэлхийн хөндлөн меркаторын UTM (UNIVERSAL TRANSVERS MERCATOR) тусгагчийг хэрэглэнэ.

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн ажлын тайлан болон зургийн shr.файлуудыг цахим хэлбэрээр /CD, DVD/ 1 хувь ирүүлнэ.

**Тайланг хэлэлцүүлэн
хүлээлгэн өгөх**

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажлын тайланг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, Захиргаа, удирдлагын

**МЭРГЭШСЭН
ИНЖЕНЕР
ТЕХНИКИЙН
АЖИЛЧДЫН
ХАНГАМЖИД
ТАВИГДАХ
ШААРДЛАГА**

хэлтэс, Ойн нөөцийн хэлтэст тус тус нэг хувийг хүргүүлнэ. Тайланг зөвшөөрөх хугацааг ажлын үе шатны хуваарьт тусгасан болно. Тайланг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт нээлттэйгээр хэлэлцүүлнэ.

Тэмцлийн ажлыг зохион байгуулахад мэргэшсэн инженер техникийн болон улирлын ажилтнууд нь доорх шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

Ерөнхий инженер нь ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажил буюу гэрээгээр заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ ижил ажил гүйцэтгэсэн 5 жилийн туршлагатай байх, түүн дотроо гэрээг бие даан хариуцаж ажилласан 3 жилийн туршлагатай байх

Инженер техникийн ажилтан нь ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажил буюу гэрээгээр заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ ижил ажил гүйцэтгэсэн 3 жилийн туршлагатай байх

5.0 мян/га талбай тутамд ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд 5-аас дээш жил ажилласан мэргэшсэн инженер 2-ээс доошгүй, 5.0 мян/га талбай тутамд улирлын болон түр ажилтан 20-оос доошгүй байна.

Тэмцлийн ажлыг зохион байгуулахад бусад шаардлагатай ажилчидтай /тогооч, жолооч гэх мэт/ байх

Ойн хөнөөлт шавжтай үүргийн шүршигч багаж
ашиглан тэмцэх талбайн байршил харуулсан зураг

/Хавсралт 1/

Зураг төслийн жагсаалт /тендерт оролцогч ирүүлэх/

д/д	Зураг төслийн нэр	Агуулга
1.	Тэмцлийн ажил явуулах талбайн зураг	Тэмцлийн ажил явуулахаар төлөвлөж буй аймаг, сум тус бүрээр гаргах ба ажил гүйцэтгэх арга технологи тус бүрээр газар нутгуудыг тэмдэглэх, ажил гүйцэтгэх хугацааг харуулсан байх
2.	Тэмцлийн ажилд ашиглах багажийн зураг	Багажийн маркийг бүрэн гүйцэд харуулсан байх
3.	Тэмцлийн ажилд ашиглах автомашинуудын зураг	Ажилд ашиглах машинуудын зургийг тус бүрд нь харуулах
4.	Тэмцлийн ажилд ажиллах мотопомпнуудын зураг	Мотопомпнуудын марк, ус шахах, сорох шланжыг бүрэн гүйцэд харуулсан байх
5.	Тэмцлийн ажилд ашиглах үүргийн шүршигч багажийн зураг	Шүршигчийн марк, үзүүлэлтүүдийг гүйцэд харуулсан байх

ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

д/д	Ажлын нэр, тодорхойлолт	Тоо, хэмжээ	Нийлүүлэх хуваарь
1	Бэлтгэл ажил	-	2024-06-15-ны дотор
2	Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажил	76000 га	2024-07-10-ны дотор
3	Тэмцсэн талбайг хүлээлгэн өгөх	76000 га	2024-07-10-ны дотор
4	Зөрчил, гологдол арилгах	76000 га	2024-07-10-ны дотор
5	Тайлан боловсруулалтын ажил	-	2024-10-01-ний дотор
6	Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх	-	2024-11-10-ны дотор

**ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖТАЙ ҮҮРГИЙН ШҮРШИГЧ БАГАЖ АШИГЛАН ТЭМЦЭХ
ТЭМЦЛИЙН АЖИЛ ЯВУУЛАХ ГАЗАР НУТГУУД**

ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖТАЙ ҮҮРГИЙН ШҮРШИГЧ БАГАЖ АШИГЛАН ТЭМЦЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ-2024						
д/д	Аймаг нэр	Сумын нэр	Тэмцлийн ажил явуулах талбай, га		ОЗБ хийсэн огноо	Зүйлийн нэр
			Үүргийн шуршигч	Хэсэглэлийн дугаар		
Багц-1. Үүргийн шуршигч багаж ашиглан ойн хөнөөлт шавжтай тэмцэх						
1	Булган	Баян-Агт	5000	81-87, 102, 103, 113-116, 118-121, 125	2020	Якобсоны төөлүүрч эрвээхэй
2		Орхон	3000	53, 54, 29, 30, 31, 32		Якобсоны төөлүүрч эрвээхэй
3		Сайхан	2000	2, 3, 4, 5, 31, 30, 20, 29, 19,		Якобсоны төөлүүрч эрвээхэй
4		Бүрэгхангай	2000	42, 43, 48, 49, 50, 51		Якобсоны төөлүүрч эрвээхэй
5		Хангал	2000	78, 79, 80, 89, 90, 91, 93, 94, 108, 109, 129, 52, 53, 54		Якобсоны төөлүүрч эрвээхэй
6		Хутаг-Өндөр	6000	115, 116, 117, 118, 119, 44, 75, 144, 145, 146, 147, 148		Якобсоны төөлүүрч эрвээхэй, Шинэсний шилмүүс хуйлагч
7	Орхон	Жаргалант	2000	1-3, 7, 9, 12, 16, 22, 31,	2022	Якобсоны төөлүүрч эрвээхэй, Шинэсний шилмүүс хуйлагч
8	Сэлэнгэ	Баруунбүрэн	4000	62,68,70,81,82,91,102,103,104,112,113,114,121-132,143	2019	Сибирийн хүр эрвээхэй, Якобсоны төөлүүрч эрвээхэй
9		Сант	2000	1,2,7,8,9,10,11,12,13,14,15,16,19,24,29,31		Сибирийн хүр эрвээхэй, Якобсоны төөлүүрч эрвээхэй
10		Цагааннуур	2000	52,61,62,72,73,90,91,94,95,138,148,141,127,128,129,143,144		Шинэсний шилмүүс хуйлагч
11		Түшиг	2000	108, 109,128,127,130		Шинэсний шилмүүс

						хуйлагч
Дүн		32000				
Багц-3. Үүргийн шүршигч багаж ашиглан ойн хөнөөлт шавжтай тэмцэх						
1	Хөвсгөл	Алаг-Эрдэнэ	2000	187, 188, 217, 220	2012	Якобсоны төөлүүрч эрвээхэй
2		Түнэл	2000	185, 186, 187		Якобсоны төөлүүрч эрвээхэй, Өрөөсгөл хүр эрвээхэй
3		Баянзүрх	1000	291, 293, 295		Якобсоны төөлүүрч эрвээхэй
4		Галт	3000	51,52, 57,59, 61,62,67-69, 76,88, 103-108 ,113-115 ,123		Якобсоны төөлүүрч эрвээхэй
5		Жаргалант	3000	2,6 ,7 ,11,13,14,18-21, 23 ,25 ,32 ,33,36 ,44-49 ,51-56 ,69, 71,77 ,81-85		Якобсоны төөлүүрч эрвээхэй
6		Шинэ-Идэр	3000	19-24 ,61-64		Якобсоны төөлүүрч эрвээхэй
7		Төмөрбулаг	3000	60 ,62 ,73 ,87, 90 ,106		Якобсоны төөлүүрч эрвээхэй
8		Рашаант	3000	22, 23, 24, 67,54,55,69		Якобсоны төөлүүрч эрвээхэй, Шинэсний шилмүүс хуйлагч
9		Цагаан-Уул	3000	24,32.33,17,49,61		Якобсоны төөлүүрч эрвээхэй
10		Тосонцэнгэл	3000	17,1,2,7,8,9		Якобсоны төөлүүрч эрвээхэй, Шинэсний шилмүүс хуйлагч
1	Төв	Мөнгөнморьт	3000	681, 689, 664, 663, 685, 691, 743, 727, 718, 754,690,700,701,709,739,752,754,764	2015	Якобсоны төөлүүрч эрвээхэй, Шинэсний шилмүүс хуйлагч
2		Баяндэлгэр	1000	55, 56,57, 58,59,60,61,62 63, 67, 69		Якобсоны төөлүүрч эрвээхэй, Шинэсний шилмүүс хуйлагч

3		Батсүмбэр	3000	81, 82, 90, 94, 104, 110, 106, 147, 187, 193, 202		Сибирийн хүр эрвээхэй, Якобсоны төөлүүрч эрвээхэй
4	Хэнтий	Батширээт	2000	385, 416, 546, 547, 548, 604, 605, 583,541,549	2013	Якобсоны төөлүүрч эрвээхэй, Урын ялаа
5		Баян-Адрага	1000	10, 11, 15, 16, 23, 31, 35, 40, 47, 50		Якобсоны төөлүүрч эрвээхэй, Моносны бүгэг эрвээхэй
6		Биндэр	2000	254, 255, 256, 257, 258, 259, 260, 261		Якобсоны төөлүүрч эрвээхэй, Шинэсний шилмүүс хуйлагч эрвээхэй
7		Өмнөдэлгэр	2000	609,611,612,613,730,731,637, 638, 683,684,721,723,726		Якобсоны төөлүүрч эрвээхэй, Өрөөсгөл хүр эрвээхэй,
8		Цэнхэрмандал	4000	59, 60, 61, 86, 87,99,100, 101, 115, 126,122, 124, 125, 127, 131		Якобсоны төөлүүрч эрвээхэй, Өрөөсгөл хүр эрвээхэй, Урын ялаа
			44000			
		Нийт дүн	76000			

Жич: Ойн хөнөөлт шавжтай үүргийн шүршигч багаж ашиглан тэмцэх аймаг, сумдын ойн сангийн ойн зохион байгуулалтын хэсэглэл, ялгарлын дугаар, газарзүйн байршлыг ойн хөнөөлт шавжийн тархалт, голомтыг тогтоох судалгааны дүн болон тэмцлийн ажил гүйцэтгэх үед шавжийн тархалт голомтоос шалтгаалан өөрчлөгдөж болно. Өөрчлөгдсөн тохиолдолд захиалагчаас томилогдсон төслийн менежертэй зөвшилцсөний үндсэн дээр өөрчлөлтийг хийнэ.

ТЭМЦЛИЙН АЖИЛД ХЭРЭГЛЭГДЭХ БЭЛДМЭЛ БОДИСЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд хэрэглэгдэх бэлдмэл бодис болон холбогдох үйлчилгээ нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна. Үүнд:

1. <i>Bacillus thuringiensis</i> var <i>kurstaki</i> эсхүл түүнтэй дүйцэх омгийн био бэлдмэл	
<i>Бараа болон холбогдох үйлчилгээний нэр</i>	<i>Техникийн тодорхойлолт болон стандарт</i>
<p><i>Bacillus thuringiensis</i> <i>var kurstaki</i> эсхүл түүнтэй дүйцэх омгийн био бэлдмэл</p>	<p>Ойн зонхилох хөнөөлт шавжийн хүрэнцэртэй тэмцэхэд хэрэглэдэг <i>Bacillus thuringiensis</i> var <i>kurstaki</i> омгоор үйлдвэрлэгдсэн био бэлдмэл</p> <ol style="list-style-type: none"> 1. Уг био бэлдмэл нь 2023 онд батлагдсан хөдөө аж ахуйд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох био бэлдмэлүүдийн жагсаалтад орсон байх. 2. Уг био бэлдмэл нь 2024 онд шинээр батлагдах хөдөө аж ахуйд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох био бэлдмэлүүдийн жагсаалтад орсон байна. 3. Бодисын техникийн тодорхойлолтын үзүүлэлттэй холбогдох заалтыг баталгаажуулан 1 хувь буюу эх болон хуулбар хувьтай хамт ирүүлнэ. 4. Санал болгож буй бодис үйлдвэрлэгчийн тухай танилцуулгыг баталгаажуулан ирүүлнэ. 5. Уг омгийн бактерийн бэлдмэл нь 1 мл-тээ 18.4 тэрбумаас доошгүй спор агуулсан байх 6. Санал болгож буй бэлдмэлийн танилцуулга ирүүлнэ. Танилцуулгадаа хэрэглэх заавар, нэг га талбайд зарцуулах бодисын хэмжээ, физик, химийн шинж чанар, үйлчилгээний механизм, савлалт, хадгалалтын горим, тээвэрлэлтийн талаарх мэдээлэл, тухайн бэлдмэл, түүний хольцыг устгах аргачлал, хүний эрүүл мэнд, байгальд хэрхэн нөлөөлөх талаар болон хүн амьтан хордохоос урьдчилан сэргийлэх заавруудыг багтаасан байна. 7. Барааны шошготой байна. Шошго нь дараах мэдээллүүдийг агуулсан байх шаардлагатай. Үүнд: <ul style="list-style-type: none"> ➤ Худалдааны болон ердийн нэр ➤ Үйлдвэрлэгчийн нэр хаяг ➤ Үйлдвэрлэсэн огноо ➤ Бэлдмэлийн хүчинтэй хугацаа ➤ Үхлийн тун хэмжээ ➤ Олон улсын бүртгэлийн дугаар /CAS №/ ➤ Ашиглах, хэрэглэх заавар ➤ Хадгалах, тээвэрлэх заавар ➤ Хоргүйжүүлэх заавар 8. Бэлдмэлийн талаарх тухайн орны стандарт, чанарын гэрчилгээ, түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ. 9. Тухайн бодисыг таних, дээж авах, түүнийг шинжлэх арга зүйг монгол хэл дээр ирүүлнэ. 10. Ургамал хамгаалах бодис үйлдвэрлэх, импортлох, борлуулах тусгай зөвшөөрлийн хуулбарыг ирүүлнэ.

2. Bacillus thuringiensis var kurstaki Лепидоцид СК эсхүл түүнтэй дүйцэх био бэлдмэл	
<i>Бараа болон холбогдох үйлчилгээний нэр</i>	<i>Техникийн тодорхойлолт болон стандарт</i>
<p>Bacillus thuringiensis var kurstaki Лепидоцид СК эсхүл түүнтэй дүйцэх био бэлдмэл</p>	<p>Ойн зонхилох хөнөөлт шавжийн хүрэнцэртэй тэмцэхэд хэрэглэдэг <i>Bacillus thuringiensis var kurstaki</i> болон <i>dakota</i> омгоор үйлдвэрлэгдсэн био бэлдмэл</p> <ol style="list-style-type: none"> 1. Уг био бэлдмэл нь 2023 онд батлагдсан хөдөө аж ахуйд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох био бэлдмэлүүдийн жагсаалтад орсон байх. 2. Уг био бэлдмэл нь 2024 онд шинээр батлагдах хөдөө аж ахуйд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох био бэлдмэлүүдийн жагсаалтад орсон байна. 3. Бодисын техникийн тодорхойлолтын үзүүлэлттэй холбогдох заалтыг баталгаажуулан 1 хувь буюу эх болон хуулбар хувьтай хамт ирүүлнэ. 4. Санал болгож буй бодис үйлдвэрлэгчийн тухай танилцуулгыг баталгаажуулан ирүүлнэ. 5. Уг омгийн бактерийн бэлдмэл нь 1 мл-тээ 10.0 тэрбумаас доошгүй спор агуулсан байх 6. Санал болгож буй бэлдмэлийн танилцуулга ирүүлнэ. Танилцуулгадаа хэрэглэх заавар, нэг га талбайд зарцуулах бодисын хэмжээ, физик, химийн шинж чанар, үйлчилгээний механизм, савлалт, хадгалалтын горим, тээвэрлэлтийн талаарх мэдээлэл, тухайн бэлдмэл, түүний хольцыг устгах аргачлал, хүний эрүүл мэнд, байгальд хэрхэн нөлөөлөх талаар болон хүн амьтан хордохоос урьдчилан сэргийлэх заавруудыг багтаасан байна. 7. Барааны шошготой байна. Шошго нь дараах мэдээллүүдийг агуулсан байх шаардлагатай. Үүнд: <ul style="list-style-type: none"> ➤ Худалдааны болон ердийн нэр ➤ Үйлдвэрлэгчийн нэр хаяг ➤ Үйлдвэрлэсэн огноо ➤ Бэлдмэлийн хүчинтэй хугацаа ➤ Үхлийн тун хэмжээ ➤ Олон улсын бүртгэлийн дугаар /CAS №/ ➤ Ашиглах, хэрэглэх заавар ➤ Хадгалах, тээвэрлэх заавар ➤ Хоргүйжүүлэх заавар 8. Бэлдмэлийн талаарх тухайн орны стандарт, чанарын гэрчилгээ, түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ. 9. Тухайн бодисыг таних, дээж авах, түүнийг шинжлэх арга зүйг монгол хэл дээр ирүүлнэ. 10. Ургамал хамгаалах бодис үйлдвэрлэх, импортлох, борлуулах тусгай зөвшөөрлийн хуулбарыг ирүүлнэ.

Жич: Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд хэрэглэгдэх бэлдмэл бодис техникийн тодорхойлолтын үзүүлэлт бүрийг хангаж байгаа гэдгийг нотлох баримт бичгийг /үйлдвэрлэгчийн хэвлэж гаргасан танилцуулга, үйлдвэрлэгчийн лабораторийн шинжилгээний дүгнэлт болон бусад холбогдох баримт бичгүүд/ хавсаргасан байна.

- Тендерт оролцогчийн санал болгосон био бэлдмэлийн техникийн тодорхойлолтын үзүүлэлт бүрийг үнэн зөв гэдгийг нотлох баримт бичгийг ирүүлнэ.
- **Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд хэрэглэгдэх бэлдмэл бодис нь хэдэн мм-ийн хур тунадас, ямар хугацаанд ороход угаагдахыг үйлдвэрийн туршилтын дүнг баталгаажуулан хавсарган ирүүлнэ.**
- **Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд хэрэглэгдэх бэлдмэлийн хэдэн грамм шингэн өсгөвөр, шавжийн хүрэнцрийн хоол боловсруулах эрхтнээр дамжин хэдэн цагийн дараа үхүүлж, техникийн үр дүн хэдэн хувь үзүүлдгийг үйлдвэрийн туршилтын дүнг баталгаажуулан хавсарган ирүүлнэ.**
- Био бэлдмэлийн техникийн тодорхойлолтын үзүүлэлт бүрийг хангаж байгаа гэдгийг нотлох баримт бичиг үйлдвэрлэгчийн хэвлэж гаргасан танилцуулга, үйлдвэрлэгчийн лабораторийн шинжилгээний дүгнэлт, /экспортын барааны тодорхойлолтыг баталгаат орчуулгын газар орчуулсан байх, гаалийн бүрдүүлэлтийн хуудас, гаалийн лабораторийн шинжилгээний дүн/ болон бусад холбогдох баримт бичгүүд/ хавсаргасан байна.
- Нийлүүлэхээр санал болгож буй био бэлдмэл нь стандартын шаардлага хангасан эсэх талаарх итгэмжлэгдсэн 2 доошгүй лабораторид хийлгэсэн шинжилгээний дүн болон дагалдах бичиг баримтыг ирүүлнэ.

Зураг, төсөл

Зураг төслийн жагсаалт		
Зураг, төслийн дугаар.	Зураг төслийн нэр	Зориулалт
	Санал болгож буй барааны зураг	Барааны савлагаа, нэр хаяг, шошго зэргийг ойлгомжтой харуулсан гэрэл зураг

Багц-5. *Bacillus thuringiensis dakota* Bt-MN01
эсхүл түүнтэй дүйцэх био бэлдмэл

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ

<i>Нэр төрлийн дугаар</i>	<i>Бараа болон холбогдох үйлчилгээний нэр</i>	<i>Техникийн тодорхойлолт болон стандарт</i>
Багц-5.	<i>Bacillus thuringiensis dakota</i> Bt-MN01 эсхүл түүнтэй дүйцэх био бэлдмэл	<p>Ойн зонхилох хөнөөлт шавжийн хүрэнцэртэй тэмцэхэд хэрэглэдэг <i>Bacillus thuringiensis dakota</i> Bt-MN-01 омгоор үйлдвэрлэгдсэн био бэлдмэл</p> <ol style="list-style-type: none">1. Хайрсан далавчтаны багийн ойн хөнөөлт шавжтай тэмцэх <i>Bacillus thuringiensis dakota</i> Bt-MN01 био бэлдмэл техникийн шаардлага MNS 6543:2015 стандартын шаардлага хангасан байх2. Уг био бэлдмэл нь 2023 онд батлагдсан хөдөө аж ахуйд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох био бэлдмэлүүдийн жагсаалтад орсон байх.3. Уг био бэлдмэл нь 2024 онд шинээр батлагдах хөдөө аж ахуйд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох био бэлдмэлүүдийн жагсаалтад орсон байна.4. Бодисын техникийн тодорхойлолтын үзүүлэлттэй холбогдох заалтыг баталгаажуулан 1 хувь буюу эх болон хуулбар хувьтай хамт ирүүлнэ.5. Санал болгож буй бодис үйлдвэрлэгчийн тухай танилцуулгыг баталгаажуулан ирүүлнэ.6. Уг омгийн бактерийн бэлдмэл нь 1 мл-тээ 14-18 тэрбумаас доошгүй спор агуулсан байх7. Санал болгож буй бодисын танилцуулга ирүүлнэ. Танилцуулгадаа бодисын хэрэглэх заавар, нэг га талбайд зарцуулах бодисын хэмжээ, физик, химийн шинж чанар, үйлчилгээний механизм, савлалт, хадгалалтын горим, тээвэрлэлтийн талаарх мэдээлэл, тухайн бодис, түүний хольцыг устгах аргачлал, хүний эрүүл мэнд, байгальд хэрхэн нөлөөлөх талаар болон хүн амьтан хордохоос урьдчилан сэргийлэх заавруудыг багтаасан байна.8. Барааны шошготой байна. Шошго нь дараах мэдээллүүдийг агуулсан байх шаардлагатай. Үүнд:<ul style="list-style-type: none">➤ Худалдааны болон ердийн нэр➤ Үйлдвэрлэгчийн нэр хаяг➤ Үйлдвэрлэсэн огноо

		<ul style="list-style-type: none"> ➤ Бэлдмэлийн хүчинтэй хугацаа ➤ Үхлийн тун хэмжээ ➤ Олон улсын бүртгэлийн дугаар /CAS №/ ➤ Ашиглах, хэрэглэх заавар ➤ Хадгалах, тээвэрлэх заавар ➤ Хоргүйжүүлэх заавар <p>9. Бодисын талаарх тухайн орны стандарт, чанарын гэрчилгээ, түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ.</p> <p>10. Тухайн бодисыг таних, дээж авах, түүнийг шинжлэх арга зүйг монгол хэл дээр ирүүлнэ.</p> <p>11. Ургамал хамгаалах бодис үйлдвэрлэх, импортлох, борлуулах тусгай зөвшөөрлийн хуулбарыг ирүүлнэ.</p>
--	--	--

Багц-5. *Bacillus thuringiensis dakota Bt-MN01* эсхүл түүнтэй дүйцэх био бэлдмэл

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	НИЙЛҮҮЛЭГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТ
	Био бэлдмэлийн шинж чанарын үзүүлэлтүүд	
	Үзүүлэлт	Шаардлага
	Гадаад байдал	Өтгөрүүлсэн шингэн бэлдмэл
	Өнгө, үнэр	Хүрэн, эхүүн, өөрийн өвөрмөц үнэртэй
1.	Мах пептонг орчинд ургах онцлог	Гялалзсан, цайвар, гөлгөр, дугариг колони үүсгэдэг. 1.2 x 1.4 мм өргөн, 2.0 x 4.0 мм урт савханцар, Грам ⁺ , аэроб, спор үүсгэдэг.
	Кларкын орчинд ургах байдал	-
	Таныц /1мл-д байх спорын тоо/	14-18 тэрбум спор/мл
	pH	6.5 – 7.5
	Идэвх чанар	Био бэлдмэл нь шавжийн хүрэнцэрт 10 хоногт 75%-иас дээш үр дүн үзүүлдэг.
	Аюулгүй байдал	Байгаль орчин болон бүлээн цуст амьтанд сөрөг нөлөөгүй
	Бодисын ерөнхий үзүүлэлтүүд	
2.	<p>1.1. Бодисын нэр /худалдааны ба ерөнхий нэр/;</p> <p>1.2. Үйлдвэрлэгчийн нэр хаяг;</p> <p>1.3. Бодисын хэлбэр /шингэн байна/;</p> <p>1.4. Үйлдвэрлэсэн огноо /2024 онд үйлдвэрлэгдсэн байна./ ;</p> <p>1.5. Бодисын хүчинтэй байх хугацаа;</p> <p>1.6. Олон улсын бүртгэлийн дугаар /CAS№/</p>	
3.	Бодисын физик, химийн шинж чанар	
	<p>2.1. Үйлчлэх бодисын нэр, эзлэх хувь;</p> <p>2.2. Бодисын томьёо;</p>	

	2.3. Үхлийн тун /LD ₅₀ /; 2.4. Гадаад байдал /өнгө, үнэр/.	
4.	Бодисын үйлчлэх механизм 3.1. Бодисын үйлчлэх механизм /аль эд эрхтэнд үйлчлэх/ 3.2. Бодисын үйлчлэх хүрээ /шавжийг бүрэн хамрах эсэх/ 3.3. Бодисын хэрэглэсний дараах үр дүн /85%-с дээш байна/ 3.4. Бодисын хэрэглэсний дараах байгальд задрах хугацаа	
5.	Бодисын савлалт, хадгалалт, хэрэглээ 4.1. Савлагаа /50-60 литр, түүнээс илүүгүй хэмжээтэй байна/ 4.2. Нэгжид зарцуулах тун /нэг га-д 3 литрээс ихгүй байна./ 4.3. Барааны сав нь үйлдвэрлэгчийн нэг удаагийн лацтай байх ба доторх шингэний түвшнийг заасан хэмжээтэй байна 4.4. Барааны сав нь барааны чанарт нөлөөлөхгүй байх бөгөөд нарны гэрэл, ус чийг зэргээс хамгаалагдсан байна.	

БИО БЭЛДМЭЛ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Барааны тодорхойлолт	Хэмжих нэгж	Тооширхэг	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермсийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖТАЙ ТЭМЦЭХ АЖИЛД ХЭРЭГЛЭХ БИО БЭЛДМЭЛ							
<i>Bacillus thuringiensis dakota</i> Bt MN-01 эсхүл түүнтэй дүйцэхүйц биобэлдмэл	Ойн хөнөөлт шавжийн хүрэнцэртэй тэмцэхэд хэрэглэдэг <i>Bacillus thuringiensis dakota</i> Bt MN-01 био бэлдмэл	литр	30000 литр	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Дамбадар жаа дахь ЗГХА Ойн газар “Модлог ургамлын цуглуулгын цэцэрлэг” агуулахын байр	Гэрээ байгуулснаас хойш 15 хоног	Гэрээ байгуулснаас хойш 15 хоног	

ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ БА ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВААРЬ

№	Үйлчилгээний талаарх тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж
1	2	3	4
1	Бактерийн бэлдмэлийн үйлчилгээ, үзүүлж буй үр дүнг тооцох /“Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын үр дүнг тооцох ажилд тавих ерөнхий шаардлага” MNS 6534:2015 стандартын дагуу тэмцлийн ажил явуулсан 500 га талбай тутамд нэг дээж талбай байгуулан тооллого явуулж тэмцлийн ажлын үр дүнг тооцох. Тооллогын дээж талбай 20 метрийн радиустай тойрог хэлбэртэй байна./ Энэхүү холбогдох үйлчилгээ нь зөвхөн тавдугаар багцын хүрээнд хийгдэнэ.	20	ширхэг

Үйлчилгээг гүйцэтгэх газар болон дээж талбайн тоо

д/д	Сумын нэр	Тэмцлийн ажил явуулах		ОЗБ хийсэн огноо	Зүйлийн нэр	Дээж талбайн тоо	Үйлчилгээг гүйцэтгэж дуусгах огноо
		Талбай, га	Хэсэглэлийн дугаар				
Завхан аймаг							
1	Баян-Агт	5000	81-87, 102, 103, 113-116, 118-121, 125	2020	Якобсоны төөлүүрч, эрвээхэй	10	2024.06.15 – 2024.07.10
2	Орхон	3000	53, 54, 29, 30, 31, 32			6	
3	Сайхан	2000	2, 3, 4, 5, 31, 30, 20, 29, 19,			4	
ДҮН		10000				20	

Шалгалт, туршилт

Захиалагч шаардлагатай бол нийлүүлэгдэх барааны хувьд хийгдсэн байх ёстой үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалтыг холбогдох мэдээллийн хамт ирүүлэхийг тендерт оролцогчоос шаардаж болно.

Жич: Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд хэрэглэгдэх бэлдмэл бодис нь техникийн тодорхойлолтын үзүүлэлт бүрийг хангаж байгаа гэдгийг нотлох баримт бичгийн хамт заавал хавсарган ирүүлсэн байна. Үүнд:


- Тендерт оролцогчийн санал болгосон био бэлдмэлийн техникийн тодорхойлолтын үзүүлэлт бүрийг үнэн зөв гэдгийг нотлох баримт бичгийг ирүүлнэ.
- **Нийлүүлсэн бэлдмэлийг гуравдагч улсын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэх зардлыг гүйцэтгэгч тал хариуцна, шинжлүүлэхийг зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ; /Дээж авах хөндлөнгийн лабораторийн шинжээч, дээжийн зориулалтын хэмжээстэй сав бусад холбогдох зардлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна./**
- **Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд хэрэглэгдэх бэлдмэл бодис нь хэдэн мм-ийн хур тунадас, ямар хугацаанд ороход угаагдахыг үйлдвэрийн туршилтын дүнг баталгаажуулан хавсарган ирүүлнэ.**

- Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд хэрэглэгдэх бэлдмэлийн хэдэн грамм шингэн өсгөвөр, шавжийн хүрэнцрийн хоол боловсруулах эрхтнээр дамжин хэдэн цагийн дараа үхүүлж, техникийн үр дүн хэдэн хувь үзүүлдгийг үйлдвэрийн туршилтын дүнг баталгаажуулан хавсарган ирүүлнэ.
- Био бэлдмэлийн техникийн тодорхойлолтын үзүүлэлт бүрийг хангаж байгаа гэдгийг нотлох баримт бичиг үйлдвэрлэгчийн хэвлэж гаргасан танилцуулга, үйлдвэрлэгчийн лабораторийн шинжилгээний дүгнэлт, /экспортын барааны тодорхойлолтыг баталгаат орчуулгын газар орчуулсан байх, гаалийн бүрдүүлэлтийн хуудас, гаалийн лабораторийн шинжилгээний дүн/ болон бусад холбогдох баримт бичгүүд/ хавсаргасан байна.
- Нийлүүлэхээр санал болгож буй био бэлдмэл нь стандартын шаардлага хангасан эсэх талаарх итгэмжлэгдсэн 2 доошгүй лабораторид хийлгэсэн шинжилгээний дүн болон дагалдах бичиг баримтыг ирүүлнэ.

Зураг, төсөл

Зураг төслийн жагсаалт		
Зураг, төслийн дугаар.	Зураг төслийн нэр	Зориулалт
	Санал болгож буй барааны зураг	Барааны савлагаа, нэр хаяг, шошго зэргийг ойлгомжтой харуулсан гэрэл зураг

Хянасан:
Ойн нөөцийн хэлтсийн дарга



Г.БАТ

Боловсруулсан:
Ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа,
тэмцлийн асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн



Г.ЭНХБОЛД